



ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

ЖИН ХАСАХ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН БОРЛУУЛСАН ЭТГЭЭДЭД ХҮНИЙ АМЬ НАСЫГ БОЛГООМЖГҮЙГЭЭР ХОХИРООСОН ҮНДЭСЛЭЛЭЭР ЯЛ ОНОГДУУЛАВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: [2021] EWCA Crim 306

Шүүхийн шийдвэрийн огноо: 2021 оны 03 дугаар сарын 08-ны өдөр

Шүүхийн шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь Dinitrophenol (DNP) гэх бодисыг худалдан борлуулах зөвшөөрөлгүйгээр “жин хасах үйлчилгээтэй хоол хүнсний нэмэлт бүтээгдэхүүн” хэмээн сурталчилж, онлайнаар борлуулдаг байжээ. Тухайн бүтээгдэхүүнийг 21 настай эмэгтэй худалдан авч, тун хэтрүүлэн хэрэглэсний улмаас нас барсан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийн хүний эрүүл мэндэд аюултай бодисыг хууль бусаар борлуулсан үйлдэл нь хохирогчийн амь нас хохирсонтой шалтгаант холбоотой байна. Иймд хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 7 жилийн хорих ял, Европын Холбооны хүнсний аюулгүй байдлын журам² (2002)-ыг зөрчиж аюултай хүнсийг зах зээлд гаргасан гэмт хэрэгт 18 сарын хорих ял³ тус тус оногдуулж шийдвэрлэсэн.
- Давж заалдах шатны шүүхэд шүүгдэгч гаргасан гомдолдоо** “...аюултай хүнсийг борлуулсан үйлдлээ хүлээн зөвшөөрч байна. Харин хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч байна. DNP бодисыг хэтрүүлэн хэрэглэх нь л эрсдэлтэй байдаг. Хүмүүс ихэвчлэн тун хэтрүүлснээс болж амь насаа алддаг. Хохирогчийн хувьд насанд хүрсэн хүн, өөрөө дур мэдэн тунг

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.stpaulschambers.com/wp-content/uploads/2024/01/CLOWES-REBELO-2021.pdf>, Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

² Regulation (EC) No 178/2002 of the European Parliament and of the Council, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аюултай хүнсийг зах зээлд гаргахыг хориглоно” гэж заасан. <https://www.legislation.gov.uk/eur/2002/178/chapter/II> (Сүүлд үзсэн: 2025.12.10)

³ The Food Safety and Hygiene (England) Regulations (2013)-ийн 19 дүгээр зүйлийн 2(b) дэх хэсэгт “Европын Холбооны зайлшгүй мөрдөх ёстой заалтуудын аль нэгийг зөрчсөн, эсхүл биелүүлээгүй бол гэмт хэрэг үйлдсэнд тооцож, 2 жилээс хэтрэхгүй хорих, торгох ял, эсхүл хамтад нь оногдуулж болно” гэж засан. <https://www.legislation.gov.uk/ukSI/2013/2996/regulation/19> (Сүүлд үзсэн: 2025.12.10)



- хэтрүүлэн хэрэглэсэн. Түүний тун хэтрүүлэх эсэхийг урьдчилан мэдэх, хянах боломжгүй” гэжээ.
3. **Прокуророос** “...уг бүтээгдэхүүнийг хүн хэрэглэх зориулалтаар нийлүүлсэн нь хууль бус үйлдэл юм. Энэ хууль бус үйлдлийн улмаас хүн нас барсан буюу үхэлд хүргэх ноцтой аюул бүхий нөхцөл байдал үүсгэсэн тул болгоомжгүйгээр хүнийг алах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаж байна” гэжээ.
 4. **Давж заалдах шатны шүүхээс DNP** нь эм, хүнсний нэмэлт хэлбэрээр зөвшөөрөгдөөгүй, эрүүл мэндийн яаманд бүртгэлгүй, хүний эрүүл мэнд, амь насанд аюултайгаас гадна аюулгүй хэрэглээний тун гэж байхгүй. Английн Нийгмийн эрүүл мэндийн байгууллага болон Хүнсний аюулгүй байдлын байгууллагаас DNP-г жин хасах зорилгоор хэрэглэх нь аюултай талаар олон нийтэд анхааруулж, борлуулалтыг зогсоох, хориглох арга хэмжээг авч байсан. Шүүгдэгч эдгээр эрсдэл, төрийн байгууллагын анхааруулга, хяналт шалгалтын талаар бүрэн мэдэж байсан гэж дүгнэсэн.
 5. Шүүгдэгч нь Хятад Улсаас үйлдвэрийн зориулалтаар 2,4-DNP хэлбэрээр импортолж, гэртээ савлаж, нэг капсулд 250 мг (эрэгтэйчүүдэд “өдрийн тун” гэх сурталчилгаа), 125 мг (эмэгтэйчүүдэд “өдрийн тун” гэх сурталчилгаа) хэлбэрээр зарж, өөрийн үйл ажиллагааг холбогдох байгууллагаас нуун далдлахын тулд олон төрлийн онлайн нэр, нуугдмал төлбөрийн систем зэргийг ашиглан нийт 100,000 фунт орчим орлого олсон.
 6. Хохирогч нь сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эмчийн хяналтад байдаг, *Bulimia nervosa* гэх хооллолтын эмгэгтэй, өөрийн хүслийг хянах чадвар сул гэж тогтоогдсон.
 7. Шүүгдэгчийн хууль бусаар аюултай бүтээгдэхүүн борлуулсан үйлдэл нь хохирогчийн нас баралтын шууд шалтгаан байх ёстой. Хохирогчид зохих мэдээлэл, анхааруулга өгөөгүй, хүний эрүүл мэнд, амь насанд аюултай химийн бодисыг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хэмээн зах зээлд борлуулсан үйлдэл нь хохирогчийн амь насанд учирсан хохиролтой шууд шалтгаант холбоотой байна.
 8. Иймд шүүгдэгчийн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.